ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/30/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2022 он | Аудитын газрын Дарга,<br>тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар<br>Утас: 70562112<br><br>Аудитын менежер: Д.Оюунтуяа<br>Утас: 99775390<br><br>Аудитор: Х.Еркегүл<br>Утас: 99040705 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....2
3. Аудитын тайлан ....8
   3.1 Ерөнхий зүйл ....8
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....8
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....9
   3.4 Материаллаг байдал ....9
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....9
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....9
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....11
   3.8 Аудитын гол асуудал ....11
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....11
   3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....11
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....11
4. Аудитын илрүүлэлт ....12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....13
6. Албан шаардлага ....15


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.02.25 № 60

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ГЭРЭЛМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилчдад олгосон 15.0 сая төгрөгийн урамшууллыг НДШ-ийн тайланд тусгалгүй орхигдуулж, дутуу тайлагнасан, ажил олгогчоос төлөх 2.1 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас төлж зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга”-д нийцэхгүй, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.



023030083

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **161,663,487.24** | **97,411,447.54** |
| 33 | **АВЛАГА** | 9,293.00 | - |
| 335 | **Бусад авлага** | 9,293.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 9,293.00 | - |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 61,247,674.24 | 63,315,197.54 |
| 351 | **Түүхий эд материал** | 24,707,861.69 | 31,307,133.54 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,188,000.00 | 1,188,000.00 |
| 35130 | Эм боох материал | 23,519,861.69 | 30,119,133.54 |
| 354 | **Хангамжийн материал** | 31,039,812.55 | 27,048,064.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,728,850.00 | 1,990,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,651,282.55 | 24,776,014.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,659,680.00 | 281,600.00 |
| 35600 | Мал амьтад | 5,500,000.00 | 4,960,000.00 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | 100,406,520.00 | 34,096,250.00 |
| 36600 | Бусад нөөц | 100,406,520.00 | 34,096,250.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **922,785,723.68** | **896,341,224.54** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 922,785,723.68 | 896,341,224.54 |
| 392 | **Биет хөрөнгө** | 772,459,723.68 | 746,015,224.54 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 769,282,849.00 | 769,282,849.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (70,616,622.98) | (90,117,691.94) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48,200,000.00 | 48,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,925,000.00) | (31,865,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 127,575,822.41 | 144,782,922.41 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (78,815,991.19) | (96,180,855.13) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,205,415.30 | 13,205,415.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,446,748.86) | (11,292,415.10) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 150,326,000.00 | 150,326,000.00 |
| 39301 | Програм хангамж | 730,000.00 | 730,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (730,000.00) | (730,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 150,326,000.00 | 150,326,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,084,449,210.92** | **993,752,672.08** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **564,123.80** | **-** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 564,123.80 | - |
| 413 | **Өглөг** | 564,123.80 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 534,924.74 | - |
| 4136 | **Бусад өглөг** | 29,199.06 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 29,199.06 | - |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,083,885,087.12** | **993,752,672.08** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,083,885,087.12 | 993,752,672.08 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 235,269,309.00 | 235,269,309.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 235,269,309.00 | 235,269,309.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 746,470,864.42 | 656,338,449.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 746,470,864.42 | 746,470,864.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (90,132,415.04) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 102,144,913.70 | 102,144,913.70 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,084,449,210.92** | **993,752,672.08** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **647,177,150.00** | **674,813,900.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **162,205,850.00** | **51,248,400.00** |
| **Нийтлэг татварын бус орлого** | 162,205,850.00 | 21,953,500.00 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 162,205,850.00 | 21,953,500.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,841,550.00 | 12,492,400.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 151,364,300.00 | 9,461,100.00 |
| **Тусламжийн орлого** | - | 29,294,900.00 |
| Хандив тусламж /дотоод/ | | 29,294,900.00 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **484,971,300.00** | **623,565,500.00** |
| **Улсын төвлөрсөн төсвөөс** | 436,885,000.00 | 488,620,100.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 436,885,000.00 | 488,620,100.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,086,300.00 | 134,945,400.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,300,000.00 | 98,545,400.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 36,400,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,786,300.00 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **559,113,727.09** | **759,366,315.04** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **559,113,727.09** | **759,366,315.04** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 551,819,607.49 | 712,331,479.75 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 334,663,242.82 | 337,620,381.37 |
| Үндсэн цалин | 301,499,951.05 | 337,620,381.37 |
| Нэмэгдэл | 20,066,004.00 | - |
| Унаа хоолны хөнгөлөлт | 6,237,200.00 | - |
| Урамшуулал | 6,860,087.77 | - |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,213,292.05 | 43,577,757.61 |
| Тэтгэврийн даатгал | 29,756,649.59 | 30,704,209.00 |
| Тэтгэмжийн даатгал | 4,290,484.80 | 10,703,548.61 |
| ҮОМШӨ-ний даатгал | 10,166,157.66 | 1,500,000.00 |
| Эрүүл мэндийн даатгал | - | 670,000.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,149,621.33 | 28,344,710.93 |
| Гэрэл, цахилгаан | 3,561,211.33 | 3,454,430.93 |
| Түлш, халаалт | 5,867,610.00 | 10,977,280.00 |
| Цэвэр, бохир ус | 1,720,800.00 | 13,913,000.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 22,970,174.54 | 38,234,966.75 |
| Бичиг хэрэг | 937,810.00 | 1,906,800.00 |
| Тээвэр, шатахуун | 15,277,620.00 | 18,827,200.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 526,380.00 | 1,359,620.00 |
| Ном, хэвлэл | 7,500.00 | 43,000.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 280,000.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 425,426.00 | 2,639,624.55 |
| Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,688,120.00 | 3,414,450.00 |
| Бараа материал акталсны зардал | 3,107,318.54 | 9,764,272.20 |
| **Нормативт зардал** | 63,404,407.50 | 207,253,013.95 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,882,077.50 | 207,111,163.95 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 522,330.00 | 141,850.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,539,484.00 | 4,656,050.00 |
| Урсгал засвар | 5,539,484.00 | 4,656,050.00 |
| **Томилолт, зочны зардал** | 6,680,170.00 | 7,619,000.00 |
| Дотоод албан томилолт | 6,680,170.00 | 7,619,000.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,515,074.00 | 884,000.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 393,500.00 | 432,000.00 |
| Даатгалын үйлчилгээ | 537,000.00 | 452,000.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 78,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | - |
| Газрын төлбөр | 54,664.00 | - |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 407,910.00 | - |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 61,684,141.25 | 44,141,599.14 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 28,395,000.00 | 490,000.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,289,141.25 | 43,651,599.14 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,294,119.60 | 47,034,835.29 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 2,497,995.93 | 31,400,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,497,995.93 | 31,400,000.00 |
| **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,796,123.67 | 15,634,835.29 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,796,123.67 | 15,634,835.29 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **88,063,422.91** | **(84,552,415.04)** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 5,580,000.00 |
| Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 5,580,000.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (5,580,000.00) |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **88,063,422.91** | **(90,132,415.04)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 235,269,309.00 | 102,144,913.70 | 658,407,441.51 | | 995,821,664.21 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **235,269,309.00** | **102,144,913.70** | **658,407,441.51** | - | 995,821,664.21 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 88,063,422.91 | | 88,063,422.91 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **235,269,309.00** | **102,144,913.70** | **746,470,864.42** | - | **1,083,885,087.12** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **235,269,309.00** | **102,144,913.70** | **746,470,864.42** | - | **1,083,885,087.12** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **235,269,309.00** | **102,144,913.70** | **746,470,864.42** | - | **1,083,885,087.12** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (90,132,415.04) | | (90,132,415.04) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **235,269,309.00** | **102,144,913.70** | **656,338,449.38** | - | **993,752,672.08** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **495,812,850.00** | **636,057,900.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,841,550.00** | **12,492,400.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 10,841,550.00 | 12,492,400.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,841,550.00 | 12,492,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,841,550.00 | 12,492,400.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **484,971,300.00** | **623,565,500.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 436,885,000.00 | 488,620,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 436,885,000.00 | 488,620,100.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,086,300.00 | 134,945,400.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,300,000.00 | 98,545,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 36,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,786,300.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **495,812,850.00** | **636,057,900.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **495,812,850.00** | **636,057,900.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **488,138,726.33** | **588,703,064.71** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 331,293,500.00 | 340,322,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 215,336,800.00 | 222,697,281.98 |
| 210102 | Нэмэгдэл | 65,754,300.00 | 66,753,306.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,473,834.02 | 18,330,211.83 |
| 210104 | Урамшуулал | 29,728,565.98 | 32,541,799.23 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,028,200.00 | 41,430,369.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,734,700.00 | 31,785,992.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,258,900.00 | 1,968,536.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,230,996.12 | 3,074,848.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,285,803.88 | 357,344.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,517,800.00 | 4,243,647.06 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,371,611.33 | 17,766,630.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,561,211.33 | 3,454,430.93 |
| 210302 | Түлш, халаалт | 7,089,600.00 | 9,599,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,720,800.00 | 4,713,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 19,851,000.00 | 29,178,320.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,427,310.00 | 1,274,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,242,500.00 | 18,798,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 930,650.00 | 1,709,620.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 134,490.00 | 280,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,116,050.00 | 7,115,500.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 57,430,897.00 | 124,144,294.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 54,643,727.00 | 120,832,294.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,787,170.00 | 3,312,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,207,544.00 | 27,357,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,743,300.00 | 14,443,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,464,244.00 | 12,914,850.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 6,680,170.00 | 7,619,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,680,170.00 | 7,619,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,298,804.00 | 884,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 372,500.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 537,000.00 | 452,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 63,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 54,664.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 191,640.00 | - |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,977,000.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,977,000.00 | - |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,674,123.67** | **47,354,835.29** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,878,000.00 | 31,720,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,878,000.00 | 31,720,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,796,123.67 | 15,634,835.29 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,796,123.67 | 15,634,835.29 |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилттах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **496,817,400.00** | **485,477,664.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **496,817,400.00** | **485,477,664.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **496,277,400.00** | **485,157,664.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **335,887,600.00** | **335,887,600.00** |
| 210101 | Үндсэн цалин | 218,628,100.00 | 218,262,281.98 |
| 210102 | Нэмэгдэл | 65,754,300.00 | 66,753,306.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,711,000.00 | 18,330,211.83 |
| 210104 | Урамшуулал | 32,794,200.00 | 32,541,799.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,703,800.00** | **40,865,369.78** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,909,300.00 | 31,220,992.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,358,900.00 | 1,968,536.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,046,000.00 | 3,074,848.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 671,800.00 | 357,344.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,717,800.00 | 4,243,647.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **20,298,800.00** | **17,766,630.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,708,200.00 | 3,454,430.93 |
| 210302 | Түлш, халаалт | 9,605,400.00 | 9,599,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,985,200.00 | 4,713,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,038,600.00** | **25,901,920.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,350,000.00 | 1,274,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,542,500.00 | 15,522,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,710,000.00 | 1,709,620.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 320,000.00 | 280,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,116,100.00 | 7,115,500.00 |
| **2105** | **Норматив зардал** | **28,973,300.00** | **28,875,294.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,597,300.00 | 25,563,294.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,376,000.00 | 3,312,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,365,000.00** | **27,357,850.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,450,000.00 | 14,443,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,915,000.00 | 12,914,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,655,300.00** | **7,619,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,655,300.00 | 7,619,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,355,000.00** | **884,000.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 537,000.00 | 452,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 70,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 70,000.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 198,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **540,000.00** | **320,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 540,000.00 | 320,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 540,000.00 | 320,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **496,817,400.00** | **485,477,664.71** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **488,620,100.00** | **472,985,264.71** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 488,620,100.00 | 472,985,264.71 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **8,197,300.00** | **12,492,400.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,197,300.00 | 12,492,400.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **27.00** | **25.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 11.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **134,945,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **134,945,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 103,545,400.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,435,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 4,435,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 565,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 565,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,276,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,276,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 95,269,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 95,269,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,400,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,400,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **134,945,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 134,945,400.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 98,545,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,400,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь

- ✓ Байгалийн голомтот, зоонозын халдварт өвчнүүдтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
- ✓ Хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын судалгаа хийх, хүн амыг уг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх,
- ✓ Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- ✓ Монгол улсын хэмжээнд Зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжилийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх;
- ✓ Зоонозын өвчний хүний өвчлөл дэгдсэн голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах;
- ✓ Чиг үүргийн хүрээнд орон нутгийн харьяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- ✓ Чиг үүргийн хүрээнд лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 559.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд тайлант онд нийт зардал буурсан тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90.7 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь нөөцийн бараа, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | - | - | - |
| **Авлага** | 9.3 | - | (9.3) |
| **Урьдчилгаа** | - | - | - |
| **Бараа материал** | 61,247.7 | 63,315.2 | 2,067.5 |
| **Нөөцийн бараа** | 100,406.5 | 34,096.3 | (66,310.3) |
| **Үндсэн хөрөнгө** | 922,785.7 | 896,341.2 | (26,444.5) |
| **Нийт хөрөнгө** | **1,084,449.2** | **993,752.7** | **(90,696.5)** |
| **Өр төлбөр** | 564.1 | - | (564.1) |
| **Засгийн газрын сан /Орон нутгийн сан** | 235,269.3 | 235,269.3 | - |
| **Өмнөх үеийн үр дүн** | 746,470.9 | 746,470.9 | - |
| **Тайлант оны үр дүн** | | (90,132.4) | (90,132.4) |
| **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | 102,144.9 | 102,144.9 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,084,449.2** | **993,752.7** | **(90,696.5)** |
| **Нийт орлого /Үр дүнгийн тайлан** | 647,177.2 | 674,813.9 | 27,636.8 |
| **Нийт зардал /Үр дүнгийн тайлан** | 551,819.6 | 712,331.5 | 160,511.9 |

Бараа материалын дансны үлдэгдэл 63.3 сая төгрөг болж 2.1 сая төгрөг, нөөцийн бараа 34.1 сая төгрөг болж 66.3 сая төгрөгөөр буурсан нь короновируст халдварт өвчний тархалтын үед аймгийн ариутгал, халдваргүйтгэлийн нөөцийг бүрдүүлж ажилласантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 896.3 сая төгрөг болж 26.4 сая төгрөгөөр буурсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна. Тайлант онд дээд шатны байгууллагаас 3.9 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө шилжиж ирсэн, батлагдсан төсвөөс 13.3 сая төгрөгийн худалдаж авсан байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 235.3 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 674.8 сая төгрөг болж, өмнөх оноос 27.6 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 691.7 сая төгрөг болж, өмнөх оноос 160.5 сая төгрөгөөр буюу 29.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд улсын төсвөөс 488.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8.2 сая төгрөг, нийт 496.8 сая төгрөгийн санхүүжилт баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 488.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 12.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 485.5 сая төгрөгийг зарцуулж, 15.6 сая төгрөгийг улсын төсөвт өвлөрүүлсэн байна.Төсвийн гүйцэтгэл 97.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны байгууллагаас 36.4 сая төгрөгийн цалин, нэг удаагийн тэтгэмж, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс короновирус халдвар өвчний дэгдэлтийн үед хамгаалах

хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн зардлын санхүүжилт 98.5 сая төгрөг, нийт 134.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал байхгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

- ✓ Ажилчдад олгосон 15.0 сая төгрөгийн урамшууллыг НДШ-ийн тайланд тусгаагүй орхигдуулж, дутуу тайлагнасан.
- ✓ Ажил олгогчоос төлөх 2.1 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас төлж зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд аудитын дүгнэлтийг мэдээлсэн боловч нотлох баримтыг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ хэсэгт 197.6 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг, 10.2 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий 1 гүйлгээг хугацаа хоцроосон, зарлагын гүйлгээ хэсэгт 117.8 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 99.5 сая төгрөгийн 5 гүйлгээг хоцроож мэдээлсэн зэрэг 435.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнээс албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлж ажилласан, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 452.4 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч 3 албан шаардлага хүргүүллээ.

### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 4.2 .2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 4.2.3 Албан шаардлага

- ✓ Ажилчдад олгосон 15.0 сая төгрөгийн урамшууллыг НДШ-ийн тайланд тусгаагүй орхигдуулж, дутуу тайлагнасан.
- ✓ Ажил олгогчоос төлөх 2.1 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас төлж зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй.
- ✓ Шилэн дансны цахим хуудсанд аудитын дүгнэлтийг мэдээлсэн боловч нотлох баримтыг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ хэсэгт 197.6 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг, 10.2 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий 1 гүйлгээг хугацаа хоцроосон, зарлагын гүйлгээ хэсэгт 117.8 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 99.5 сая төгрөгийн 5 гүйлгээг хоцроож мэдээлсэн, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг нийт 452.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

### 4.2.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АСУУДАЛ** | | | | | | | | | | | |
| 1 | Зоонозын өвчин судлалын төв | 2 | 17.1 | | | | | 2 | 17.1 | | |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ** | | | | | | | | | | | |
| 1 | Зоонозын өвчин судлалын төв | 1 | 435.3 | | | | | 1 | 435.3 | | |
| | | | | | | | | | | | |
| Дүн | | 3 | 452.4 | | | | | 3 | 452.4 | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 35/А2370449 ХЭА-2022/30/НА-СТА-ТШЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд аудитын дүгнэлтийг мэдээлсэн боловч нотлох баримтыг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ хэсэгт 197.6 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг, 10.2 сая төгрөгийн мөнгөн дүн бүхий 1 гүйлгээг хугацаа хоцроосон, зарлагын гүйлгээ хэсэгт 117.8 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 99.5 сая төгрөгийн 5 гүйлгээг хоцроож мэдээлэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Гэрэлмаа, ерөнхий нягтлан бодогч Л.Цогтцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

023040030

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 36/А2370449 ХЭА. 2022/30/НА-ОТА-7Ш3 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ажилчдад олгосон 15.0 сая төгрөгийн урамшууллыг НДШ-ийн тайланд тусгаагүй орхигдуулж, дутуу тайлагнасан.
- Ажил олгогчоос төлөх 2.1 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас төлж зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын тайланд ажилчдын цалинг зөрүүтэй илэрхийлсэн, батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Гэрэлмаа, ерөнхий нягтлан бодогч Л.Цогтцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА